



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/638

Хэрлэн сум

“Өвөлжилт хүндэрсэн зарим сумдад
дэмжлэг үзүүлэх тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, “Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалт, аймгийн Онцгой комиссын №10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилт хүндэрсэн зарим сумдыг хохирол багатай даван туулах, малчин иргэдэд төрийн болон эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах 33,000,000 (гучин гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэх сумдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
А/638 12 дугаар сарын 25-ны
дугаар захирамжийн хавсралт

Дэмжлэг үзүүлэх сумдын нэрс

д/д	Сумдын нэрс	Мөнгөн дүн
1	Жаргалтхаан	5,000,000
2	Цэнхэрмандал	5,000,000
3	Өмнөдэлгэр	5,000,000
4	Гурванбаян	3,000,000
5	Батширээт	5,000,000
6	Биндэр	5,000,000
7	Баян-Адарга	5,000,000
	Нийт	33,000,000